

## Мэдэгдэл

---

Огноо: 2014 оны 3-р сарын 10

ЕСҮС ХРИСТИЙН  
ХОЖМЫН ҮЕИЙН  
ГЭГЭЭНТНҮҮДИЙН СҮМ

Хэнд: Ерөнхий эрх мэдэлтнүүд; Бүсийн дал; номлол болон гадас дүүргийн ерөнхийлөгч; бишоп, салбарын ерөнхийлөгчдөд

Хэнээс: Номлогчийн алба (801-240-2222)

Сэдэв: Буцаж буй номлогчдын сүрьеэгийн сорил

---

Сүрьеэ нь уушги болон бусад амин чухал эрхтнийг устгаж чадах нянгаар халдварладаг гоц халдварт өвчин юм. Сүрьеэгийн ямар нэг шинж тэмдэг шууд илрэлгүй, уг өвчний халдварыг авсан байх магадлалтай тул буцаж буй номлогчид сүрьеэгийн шинжилгээ өгөх нь маш чухал юм.

Хавсаргасан захидалд номлолын ерөнхийлөгчөөс, буцаж буй номлогчдод гэртээ харьмагцаа сүрьеэгийн шинжилгээ өгөхийг зааварласан юм. Номлолын ерөнхийлөгч нь энэхүү захидлын цахим хуулбарыг номлолын ерөнхийлөгчийн портал ([missionary.lds.org/presidents](http://missionary.lds.org/presidents)) эсвэл номлогчийн эрүүл мэндийн вэбсайтаас ([missionarymedical.org](http://missionarymedical.org)) номлолын албаны ажилтан татаж авч болно.

Бид буцаж буй номлогчид энэхүү шинжилгээг хийлгэхийг нь дэмжиж, тэднийг гэртээ хариад сүрьеэгийн сорил өгөх хүрэлцэхүйц мөнгөтэй байхад нь анхаархыг орон нутгийн санваарын удирдагчдаас хүсч байна.

Хүндэт ахлагч/Эгч \_\_\_\_\_:

Сэдэв: Сүрьеэгийн сорил

Сүрьеэ нь уушги болон бусад амин чухал эрхтнийг устгаж чадах нянгаар халдварладаг гоц халдварт өвчин юм. Дэлхийн хүн амын гуравны нэг нь уг нянгаар халдварласан өвчнөөр өвчилсөн байдаг бөгөөд халдвар авсан хүн нь ихэвчлэн ханиалгаж бусдад халдаадаг.

Ихэнхи хүмүүст сүрьеэгийн шинж тэмдэг шууд илрэлгүй, уг өвчний халдварыг авсан байдаг. Үүнийг *далд сүрьеэ* гэдэг. Хожимдвол далд сүрьеэтэй хүмүүст халдварыг намдаах боломж 10 хувь байдаг.

Тиймээс сүрьеэгийн халдвар авсан ч ноцтой шинж тэмдэг илрэхгүй байж болох тул та гэртээ хариад сүрьеэгийн сорилыг аль болох хурдан өгөх нь *маш чухал* юм. Таны номлолын өмнө өгсөн сүрьеэгийн сорилоос үл хамаарч (энэ нь сөрөг эсвэл эерэг байсан ч), та гэртээ хариад эмчид үзүүлэх, эсвэл эрүүл мэндийн газарт очиж сүрьеэгийн шинжилгээ хийлгэх хэрэгтэй. Нэмэлт шинжилгээ өгөх эсвэл эмчилгээ хийлгэх шаардлагатай болж магадгүй.

Хэрэв танд далд сүрьеэ илэрвэл та улс орныхоо эрүүл мэндийн бодлогын дагуу эмч, орон нутгийнхаа эрүүл мэндийн газрын зөвлөгөөг дагах хэрэгтэй. Амьдралынхаа турш Их Эзэний эрүүл, хүчирхэг үйлчлэг байж болохын тулд эрүүл мэнддээ анхаарал тавьсан танд баярлалаа.

Хүндэтгэсэн,

---

Номлолын ерөнхийлөгч